

**ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРЭЙШН  
("Компани")**

**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

**МакКиннес Купер компанийн оффис  
Аппэр Уотэр гудамж 1300-1969, Пурдис Варф,  
Нова Скошиа муж, Халифакс хот**

**2025 оны 6-р сарын 25, Лхагва гараг 10 цагт (Атлантын цагаар)  
зохион байгуулагдсан**

**ТАНИЛЦУУЛГА**

Эрдэнэ Ресурс Девелопмент Корпорэйшн ("Компани" эсвэл "Корпорэйшн")-ийн хувьцаа эзэмшигчид ("Хувьцаа эзэмшигчид")-ийн ээлжит хурал эхлэв. Компанийн ерөнхийлөгч, гүйцэтгэх захирал Петер Акерли өөрийгөө болон Санхүү хариуцсан захирал Роберт Женкинс-ийг танилцуулав.

**ХУРЛЫН ДАРГА, НАРИЙН БИЧИГ БА ТООЛЛОГЫН КОМИСС**

Петер Акерли нь хурлын даргаар, компанийн хуулийн зөвлөх Жюли Робинсон тэмдэглэл хөтлөх нарийн бичгээр ажиллав. Компьютершэйр Инвестор Сервисэз Инк. ("Computershare") нь тооллогын комиссоор ажилласан.

**ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

Бүртгэлтэй хувьцаа эзэмшигчдэд Компьютершэйр нь 2025 оны 5-р сарын 21-нд хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдэл хүргүүлсэн. Хурлын дарга хурлын нарийн бичигт энэхүү мэдүүлгийг хурлын тэмдэглэлд хавсаргахыг үүрэг болгов.

**ХУРЛЫН ИРЦ**

Хурлын дарга нь тооллогын комиссыг биечлэн оролцож буй хувьцаа эзэмшигчид эсвэл төлөөлөгчөөр дамжуулан оролцож буй хувьцаа эзэмшигчдийн урьдчилсан тоог гарган, хурлын ирцийн талаар танилцуулахыг Тооллогын коммист ажилласан Коллейн Нейлсэнд үүрэг болгов. Хурлын дарга нь хувьцаа эзэмшигчдийн хурлын ирц бүрдсэнийг танилцуулав. Хурлын дарга нь энэхүү хувьцаа эзэмшигчдийн хурал нь хүчин төгөлдөр болохыг танилцуулан, тооллогын комиссыг хурлын ирцийн талаар эцсийн тайланг боловсруулахыг үүрэг болгов.

**ХУРЛЫН ҮЙЛ ЯВЦ**

Хурлын дарга нь хурлын хөтөлбөр, үйл явцыг танилцуулав. Хурлын дарга нь хөтөлбөрт дараах асуудлыг хэлэлцэх болохыг тайлбарлав:

- i. 2024 оны 6-р сарын 20-нд зохион байгуулагдсан хувьцаа эзэмшигчдийн хурлын тэмдэглэлийг хянан баталгаажуулах;
- ii. 2024 оны 12-р сарын 31-ээр дуусгавар болсон аудитаар баталгаажсан санхүүгийн тайланг танилцуулах;
- iii. Компанийн ирэх жилийн ТУЗ-ийн гишүүдийг сонгон, томилох;
- iv. Компанийн ирэх жилийн аудиторыг сонгон, томилох;
- v. Компанийн хувьцаа эзэмшигчийн эрхийн төлөвлөгөөг цуцлах тухай хэлэлцэн, зөвшөөрвөл цуцлах тогтоол гаргах;
- vi. Компанийн нийт гаргасан энгийн хувьцааг нэгтгэх буюу нэгтгэлээс өмнөх зургаан (6) энгийн хувьцааг нэг (1) шинэ энгийн хувьцаанд хөрвүүлэх харьцаагаар нэгтгэх үйл ажиллагааг гүйцэтгэх эрхийг ТУЗ-д өгөх тусгай тогтоолыг хэлэлцэх, зөвшөөрвөл тусгай тогтоол гаргах
- vii. Хурлын өмнө гарсан, цаашид зохицуулах шаардлагатай болон бусад асуудал.

Хурлын дарга шийдвэрүүдийг уншиж танилцуулах ба санал оруулж, саналыг дэмжих эсэхийг асууна. Санал хураалт явагдана.

## **2024 ОНЫ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

Хурлын дарга нь 2024 оны 6-р сарын 20-нд зохион байгуулагдсан хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тэмдэглэлтэй хувьцаа эзэмшигчид өөрийн хүсэлтээр танилцах боломжтойг тэмдэглэв.

Санал хураалтаар 2024 оны 6-р сарын 20-нд зохион байгуулагдсан хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тэмдэглэлтэй хувьцаа эзэмшигчид танилцсан гэдгийг баталгаажуулав.

## **САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

Хурлын дарга нь 2024 оны 12-р сарын 31-нд дуусгавар болсон санхүүгийн тайлан, тодруулга болон аудиторын тайланг хувьцаа эзэмшигчдэд танилцуулав. Мөн хурлын дарга нь санхүүгийн тайлан нь SEDAR+-т тайлагнан, хувьцаа эзэмшигчдэд хүргүүлснийг дурдав. ТУЗ-ийн дарга аудитын дүгнэлт нь цэвэр ба зөрчилгүй гарсныг тэмдэглэв. Санхүүгийн тайлан болон аудиторын тайлантай холбоотой асуулт байхгүй байв.

## **ТУЗ-ИЙН ГИШҮҮДИЙГ СОНГОН, ТОМИЛОХ**

Хурлын дарга нь дараагийн асуудал болох ТУЗ-ийн гишүүдийг сонгон, томилох талаар танилцууллаа. Хурлын дарга нь ирэх жилд ТУЗ нь таван (5) гишүүнээс бүрдэн үйл ажиллагаа явуулахыг онцлов. Хурлын эцэст ТУЗ нь таван (5) гишүүнээс бүрдэх болов.

Дараах таван нэр дэвшигч ТУЗ-д нэр дэвшиж байгааг хурлын дарга танилцуулав:

Др. Анна Биолик

Лэйтон Крофт

Кеннет МакДоналд

Камерон МакРэй болон

Петер Акерли

Хурлын дарга нь Компанийн дүрмийн дагуу хурлын үеэр нэмж ТУЗ-д нэр дэвших гишүүнийг хүлээн зөвшөөрөхгүйг танилцуулав.

Санал хураахаас өмнө хурлын дарга ТУЗ-ийн гишүүн Дэвид Мошер болон Хэдли Виддап нь үүрэгт ажлаа хүлээлгэж өгч буйтай холбогдуулан компанид оруулсан үнэтэй хувь нэмрийг цохон тэмдэглэж, талархал илэрхийлэв.

Хурлын дарга нь Компьютершэйрт бүх бүртгэлтэй хувьцаа эзэмшигчдээс авсан саналыг нэгтгэх үүрэг өгөв. Компьютершэйр саналын хуудасны тайланг танилцуулж, тайлангийн хуулбарыг Хавсралт С-д хавсаргасныг мэдээлэв. Нэр дэвшүүлж, санал хурааснаар Др. Анна Биолик, Лэйтон Крофт, Кэннет МакДоналд, Камерон МакРэй болон Петер Акерли нарыг компанийн ТУЗ-ийн гишүүдээр томилж, дараагийн гишүүд томилогдох хүртэл ТУЗ-ийн гишүүдийн ажлыг гүйцэтгэхээр томилов.

### **АУДИТОРЫГ ТОМИЛОХ**

Хэлэлцүүлэх дараагийн асуудалд дараагийн хувьцаа эзэмшигчдийн хурал, эсвэл дараагийн компани томилогдох хүртэл Компанийн аудитораар ажиллах байгууллагыг сонгон томилох, ТУЗ-д аудиторын цалин урамшууллыг тогтоох эрхийг олгох асуудлыг хэлэлцсэн.

Нэр дэвшүүлж, санал хурааснаар мэргэшсэн нягтлан бодогчид Эм Эн Пи ХХН ("MNP LLP")-г хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал эсвэл дараагийн аудитор томилогдох хүртэл компанийн аудитораар томилж, ТУЗ-д аудиторын цалин урамшууллыг тогтоох эрхийг олгохоор тогтов.

### **ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН ЭРХИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ЦУЦЛАХ**

Хурлын хэлэлцэх дараагийн асуудал нь компанийн шинэчилсэн, дахин баталсан Хувьцаа эзэмшигчийн эрхийн төлөвлөгөө ("Эрхийн төлөвлөгөө")-г цуцлах тухай тогтоолыг хэлэлцэж, шаардлагатай гэж үзвэл батлах байсан.

Хурлын дарга тухайн Эрхийн төлөвлөгөөг Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл 2017 оны 6 дугаар сарын 14-ний өдөр баталж, хүчин төгөлдөр болсныг танилцуулав. Мөн ТУЗ уг төлөвлөгөө нь хувьцаа эзэмшигчид компанид нэмэлт хөрөнгө оруулалт хийх замаар дэмжлэг үзүүлэх боломжийг хязгаарлаж байна гэж дүгнэснийг тэмдэглэв. Үргэлжлүүлэн, одоогийн зах зээлийн орчин болон санал гаргахтай холбоотой дүрэм журмыг харгалзан үзвэл, Эрхийн төлөвлөгөөнд туссан зорилго, чиглэлийг өөр хэлбэрээр хэрэгжүүлэх боломжтой бөгөөд Эрхийн төлөвлөгөөг цуцлах нь компанийн нийтлэг ашиг сонирхолд нийцнэ хэмээн ТУЗ дүгнэсэн болохыг онцлов.

Хурлын дарга уг тогтоол нь Эрхийн төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт оруулж, тус төлөвлөгөөг хуралдааны дараах ажлын өдрийн төгсгөлөөр цуцлах бөгөөд тогтоолын эх хувь нь Компанийн ХЭХ-ын мэдэгдэл болон Удирдлагын мэдээллийн танилцуулгын 15 дугаар хуудсанд тусгагдсан болохыг мэдээлэв.

Санал хураалтын үндсэн дээр санал гаргаж, дэмжсэнээр, Эрхийн төлөвлөгөөг цуцлах тухай тогтоолыг Танилцуулгын 15 дугаар хуудсанд заасан хэлбэрээр батлав.

## **ХУВЬЦААНЫ НЭГТГЭЛ**

Хурлын дараагийн хэлэлцэх асуудал нь компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулж, нийт гаргасан энгийн хувьцааг нэгтгэх тухай байв. Уг нэгтгэл нь нэгтгэлээс өмнөх зургаан (6) энгийн хувьцааг нэг (1) энгийн хувьцаанд хөрвүүлэх харьцаагаар хэрэгжих бөгөөд нэгтгэл (“Хувьцааны нэгтгэл”) хүчин төгөлдөр болох өдрийн өмнөх өдрийн хувьцааны тоонд үндэслэнэ.

Хурлын дарга нь хувьцааны нэгтгэл нь компанийн болон хувьцаа эзэмшигчдийн нийтлэг ашиг сонирхолд нийцнэ хэмээн ТУЗ үзэж буйг мэдэгдэв. Хувьцааны нэгж үнэ өсөх нь томоохон хөрөнгө оруулалтын сангууд болон бусад хөрөнгө оруулагчдын сонирхлыг нэмэгдүүлж, хөрөнгө оруулалт татах хүрээг өргөжүүлэхэд эерэг нөлөө үзүүлнэ гэж үзэж байна.

Хурлын дарга үргэлжлүүлэн, Хувьцааны нэгтгэлийг батлах тусгай тогтоолын төсөл нь Танилцуулгын 18 дугаар хуудсанд тусгагдсан болохыг дурдаад, уг тогтоол хүчин төгөлдөр болохын тулд хурлын танхимд биечлэн болон саналын хуудас хүргүүлэн оролцсон хувьцаа эзэмшигчдийн саналын гуравны хоёр (2/3)-оос доошгүй хувиар батлагдах шаардлагатайг онцлов. Түүнчлэн Торонтогийн Хөрөнгийн Биржийн зөвшөөрлийг авснаар Хувьцааны нэгтгэл нь хүчин төгөлдөр болох боломжтой ба хэрэв Төлөөлөн удирдах зөвлөл нь энэхүү нэгтгэл нь компанийн ашиг сонирхолд нийцэхгүй гэж дүгнэвэл хувьцаа эзэмшигчдийн дахин зөвшөөрөл авахгүйгээр уг үйл ажиллагааг цуцлах эрхтэй болохыг тайлбарлав.

Санал гаргаж, дэмжсэнээр, Хувьцааны нэгтгэлийг Удирдлагын мэдээллийн танилцуулгын 18 дугаар хуудсанд танилцуулснаар батлав.

## **ХУРЛЫН ХААЛТ**

Хурлын дарга хэлэлцэх нэмэлт асуудал байгаа эсэхийг тодруулав.

Хэлэлцэх нэмэлт асуудал байхгүй байсан тул хурлыг эцэслэх санал гарган зөвшөөрснөөр хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал өндөрлөв.

---

Жюли Робинсон, тэмдэглэл хөтөлсөн нарийн бичиг

Энэхүү материал нь англи хэл дээр бэлтгэгдсэн материалын орчуулга болно. Англи, монгол хувилбаруудын хооронд зөрүү эсвэл зөрчилдөх зүйл гарвал англи хэл дээрх хувийг мөрдөнө.